



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Баруун босоо тэнхлэгийн авто зам барих” төслийн хүрээнд бий болсон нийт 827,723,000.00 (найман зуун хорин долоон сая долоон зуун хорин гурван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасан төрийн өмчит авто зам, засвар арчлалтын компаниудад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Тогтоолд заасан авто зам, засвар арчлалтын компанийн гүйцэтгэх захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002237



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2018 оны 9 дугаар сарын 19-ны 397 өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

**Төрийн өмчит авто зам, засвар арчлалтын компаниудын үндсэн хөрөнгөд бүртгэх
 хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашиглалтад орсон он	ХЭМ ЖИХ НЭГЖ	ТОО ШИР ХЭГ	Анхны өртөг (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хүлээн авч бүртгэх байгууллага
1	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221 079 500,00	221 079 500,00	"Баянчандмань-АЗЗА" ТӨХК
2	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221 079 500,00	221 079 500,00	"Хөвсгөл-АЗЗА" ТӨХК
3	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221 079 500,00	221 079 500,00	"Талын зам" ТӨХК
4	Дугуйт Экскаватор FR-L619	2018	Ш	1	164 484 500,00	164 484 500,00	"Архангай-АЗЗА" ТӨХК
				4	827 723 000,00	827 723 000,00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			4 (дөрөв)	827,723,000.00 (найман зуун хорин долоон сая долоон зуун хорин гурван мянган)	827,723,000.00 (найман зуун хорин долоон сая долоон зуун хорин гурван мянган)	